

ЦАХИЛГААН СКУУТЕР, СУРРОН ДУГУЙ, ЦАХИЛГААН МОТОРТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ ОСОЛ, ГЭМТЛЭЭС ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ИРГЭДИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Б.Дэнзэнноргой

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 7081 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн дэд хурандаа

Хураангуй: Монгол Улсад 2023 онд 25,235 зам тээврийн осол бүртгэгдсэнээс 482 ослын улмаас 551 хуний амь нас хохирчээ. Нийслэлд 98 ослын улмаас 101, орон нутгийн замд 384 ослын улмаас 450 хуний амь нас тус тус хохирсон байна.

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүнийг хөдөлгөөнд оролцсон хэлбэрээр нь авч үзвэл 28.6 хувийг явган зорчигч, 39.6 хувийг зорчигч, 45.4 хувийг жолооч, 0.4 хувийг унадаг дугуйтай зорчигч тус тус эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхэд, залуучууд цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуй, скүүтер, мопед, мотоцикл унаж, замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдэж, зам тээврийн осолд өртөж, өөрт болон бусдад эрүүл мэнд, эд материалын хохирол учруулах, бусдын хэвийн аюулгүй зорчих эрхэд нөлөөлөх, стресс бухимдалд оруулах нөхцөл үүсээд байна.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд мотоциклтой осол 1,422 бүртгэгдсэнээс 305 хүн нас барж, 733 хүн гэмтсэн бол унадаг дугуйтай осол 357 бүртгэгдсэнээс 8 хүн нас барж, 263 хүн гэмтсэн харамсалтай тоон мэдээ гарсан.

Дэлхий нийтээр 2020 оныг хүртэл иргэдийг замын хөдөлгөөнд оролцоход нь жолооны үнэмлэх, хамгаалах малгай (хамгаалалтын хэрэгсэл) шаардахгүйгээр хөдөлгөөнд оролцуулж байсан байна.

Харин 2020 оноос дээрх тээврийн хэрэгслийн хэрэглээ хяналтаас гарч Нидерланд, Ирланд, Грек, Франц, Канад, Индонез зэрэг улсуудад замын хөдөлгөөнд оролцуулахыг бүрэн хориглосон.

Цахилгаан дугуй болон скүүтертэй холбоотой ослууд дэлхийд, тэр дундаа АНУ-д маш ихээр нэмэгдэж байна. 2017-2022 оны хооронд цахилгаан дугуйтай холбоотой осол жил бүр хоёр дахин өссөн бол цахилгаан скүүтерийн осол жил бүр 45%-иар нэмэгдсэн байна.

Abstract: In 2023, 25,235 traffic accidents were registered in Mongolia, of which 551 people lost their lives due to 482 accidents. 101 people lost their lives due to 98 accidents in the capital, and 450 people lost their lives due to 384 accidents on local roads.

Considering the type of road traffic accidents, 28.6 percent were pedestrians, 39.6 percent were passengers, 45.4 percent were drivers, and 0.4 percent were bicycle passengers.

In recent years, teenagers and young people ride electric bicycles, scooters, mopeds, and motorcycles and participate in road traffic. There is an entry condition.

In the past 3 years, 305 people died and 733 people were injured out of 1,422 motorcycle accidents, while 8 people died and 263 people were injured out of 357 bicycle accidents.

Around the world, until 2020, citizens were allowed to participate in traffic without requiring a driver's license or helmet (protective equipment).

However, from 2020, the use of these vehicles has gone out of control, and they have been completely banned from driving in countries such as the Netherlands, Ireland, Greece, France, Canada, and Indonesia.

Accidents involving e-bikes and scooters are on the rise worldwide, including in the United States. Between 2017 and 2022, accidents involving e-bikes doubled annually, while accidents involving electric scooters increased by 45% annually.

Түлхүүр үг: цахилгаан скүүтер, цахилгаан мопед, мотоцикл, зам тээврийн осол

Keywords: electric scooters, electric mopeds, motorcycles, traffic accidents

Удиртгал:

Монгол Улсын анхны Замын хөдөлгөөний дүрэм 1925 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Ардын Засгийн газрын 18 дугаар хурлаар “Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг БНМАУ-ын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм” нэртэй батлагдсанаас хойш 1930, 1936, 1940, 1950, 1957, 1960, 1966, 1985, 1991, 1996, 2004, 2018 онуудад буюу нийтдээ 13 удаа шинэчлэгдэж, 1976, 1987, 1993, 1998, 2003 онуудад нэмэлт, өөрчлөлт орж, тухайн үеийн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, авто тээврийн салбарын бүтээн байгуулалт, автомашин жилт, замын хөдөлгөөний зохион байгуулалтын ололт дэвшилтүүд, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, зорилт, эрх зүйн шинэчлэлтэй холбогдон улам бүр боловсронгуй болж хөгжиж ирсэн түүхтэй.

Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм нь замын хөдөлгөөнд ард иргэдийг хэрхэн оролцож амар тайван, осол, эндэгдэлгүй амьдрах үндсийг замын хөдөлгөөний дүрмээр тодорхойлж байдаг.

Улсын хэмжээнд 2023 онд зам тээврийн ослын 25,235 бүртгэгдсэнээс 21,053 буюу 83.4% нь Нийслэлд, 4,182 буюу 16.6% нь орон нутагт тус тус бүртгэгдсэн байна.¹

Бүртгэгдсэн зам тээврийн ослын 21,161 буюу 83.9 хувь нь мөргөлдөх, 1,581 буюу 6.3 хувь нь явган зорчигч мөргөх, 1,049 буюу 4.2 хувь нь онхолдох, 893 буюу 3.5 хувь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/, 34 буюу 0.1 хувь нь зорчигч унагах, 119 буюу 0.5 хувь нь унадаг дугуйтай хүн мөргөх, 332 буюу 1.3 хувь нь мал, амьтан дайрах, 66 буюу 0.3 хувь нь бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.²

¹ ТЦА, “Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл”, УБ 2024, 15 дахь тал.

² ТЦА, “Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл”, УБ 2024, 18 дахь тал.

Монгол Улсад 2023 онд 25235 зам тээврийн осол бүртгэгдсэнээс 482 ослын улмаас 551 хүний амь нас хохирчээ. Нийслэлд 98 ослын улмаас 101, орон нутгийн замд 384 ослын улмаас 450 хүний амь нас тус тус хохирсон байна.

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүнийг хөдөлгөөнд оролцсон хэлбэрээр нь авч үзвэл 28.6 хувийг явган зорчигч, 39.6 хувийг зорчигч, 45.4 хувийг жолооч, 0.4 хувийг унадаг дугуйтай зорчигч тус тус эзэлж байна.

Зам тээврийн ослын улмаас 2023 онд 3,059 хүн гэмтсэн ба 1,895 буюу 61.9 хувь нь Нийслэлд, 1,164 буюу 38.1 хувь нь орон нутгийн зам бүртгэгдсэн байна.

Зам тээврийн осол, гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн насны байдлаас үзэхэд зам тээврийн осолд өртсөн 3,610 хүний 0-17 насны 953 буюу 26.3 хувь, 18-34 насны 1,122 буюу 31.3 хувь, 35-54 насны 1,200 буюу 33.2 хувь, 55 бас түүнээс дээш насны 335 буюу 9.2 хувийг тус тус эзэлж байна.

Зам тээврийн осол, гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрээр авч үзвэл 746 буюу 20.6 хувь нь жолооч, 1,049 буюу 29.1 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 1,699 буюу 47.1 хувь нь явган зорчигч, 116 буюу 3.2 хувь нь дугуйтай зорчигч хэлбэрээр хөдөлгөөнд оролцсон байна.¹

Манай улс нь замын хөдөлгөөний аюулгүй байдал болон түгжрэлийн асуудлаар дэлхийн дунджаас доогуурт тооцогддог. Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөн нь түгжрэл өндөртэй, зохион байгуулалт муу, замын эвдрэл

ихтэй байдаг нь аюулгүй байдалд нөлөөлж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын байгууллагууд, тэр дундаа Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр сайжруулах ажил хийгдэж байгаа хэдий боловч замын хөдөлгөөний осол, түгжрэлийн түвшнээр дэлхийд доогуур байранд жагсаж байна.

Манай улсад 100 мянган хүн тутмын 21 нь зам тээврийн ослоор нас бардаг бөгөөд энэ үзүүлэлт бүс нутгийн хэмжээнд өндөр үзүүлэлтэд тооцогддог байна.

Дэлхийн дунджаар энэ тоо 100 мянган хүн тутамд 17 байдаг гэж Дэлхийн банкны судалгаанд дурджээ.²

Үндсэн хэсэг: Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхэд, залуучууд цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуй, скүүтер, мопед, мотоцикл унаж, замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдэж, зам тээврийн осолд өртөж өөрт болон бусдад эрүүл мэнд, эд материалын хохирол учруулах, бусдын хэвийн аюулгүй зорчих эрхэд нөлөөлөх, стресс бухимдалд оруулах нөхцөл үүсээд байна.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд мотоциклтой осол 1,422 бүртгэгдсэнээс 305 хүн нас барж, 733 хүн гэмтсэн бол унадаг дугуйтай осол 357 бүртгэгдсэнээс 8 хүн нас барж, 263 хүн гэмтсэн харамсалтай тоон мэдээ гарсан.

2023 онд суррон, скүүтер төрлийн тээврийн хэрэгсэл холбогдсон 60 (скүүтер 28, суррон 32) осол бүртгэгдсэн бол 2024 оны эхний 07 сарын байдлаар унадаг дугуй, скүүтер, сурронтой холбоотой 241 зам тээврийн осол бүртгэгдэж, үүнээс 229 буюу 95

¹ ТЦА, "Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл", УБ 2024, 50 дахь тал.

² <https://www.worldbank.org/mn/news/press-release/2021/06/23/world-bank-to-support-sustainable-urban-transport-in-ulaanbaatar>

хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна. "Суррон болон скүүтер, унадаг дугуйтай холбоотой зам тээврийн ослын улмаас 121 хүн гэмтсэн байна.

Улаанбаатар хотод өнгөрсөн жилээ цахилгаан скүүтер, цахилгаан мопед түрээсийн үйлчилгээ нэвтэрсэн ба ийм төрлийн үйлчилгээ үзүүлдэг 3 аж ахуй нэгж байна. Үүнээс "Jet Scooter" буюу цэнхэр цахилгаан скүүтер 6,000 ширхэг, "Тара scooter" буюу улбар шар цахилгаан скүүтер 700 ширхэг, "Есо bike" буюу ногоон цахилгаан мопед 650 ширхэг түрээсийн үйлчилгээнд гарч ашиглагдаж байна.

Нийслэлд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслээс иргэдийн гол анхаарлыг татаж байгаа скүүтер, суррон загварын тээврийн хэрэгсэл холбогдсон 60 (скүүтер 28, суррон 32) осол 2023 онд бүртгэгдсэн бол 2024 оны дулааны улирал эхэлсэн 3-5 саруудад 112 осол гарч 75 хүн гэмтсэн байна.

Цахилгаан скүүтер, цахилгаан дугуй гадаадын зарим оронд 2017 оноос эхлэн өргөнөөр хэрэглэж эхэлсэн бөгөөд замын хөдөлгөөний ачааллыг тодорхой хувиар бууруулах, агаарын бохирдлыг багасгахад эерэг нөлөө үзүүлдэг гэсэн судалгааг "NRCC" олон улсын судалгааны байгууллагаас гаргасан.

Дэлхий нийтээр 2020 оныг хүртэл иргэдийг замын хөдөлгөөнд оролцоход нь жолооны үнэмлэх, хамгаалах малгай (хамгаалалтын хэрэгсэл) шаардахгүйгээр хөдөлгөөнд оролцуулж байсан байна.

Харин 2020 оноос дээрх тээврийн хэрэгслийн хэрэглээ хяналтаас гарч Нидерланд, Ирланд, Грек, Франц, Канад, Индонез зэрэг улсуудад замын хөдөлгөөнд оролцуулахыг бүрэн хориглосон.

Цахилгаан дугуй болон скүүтертэй холбоотой ослууд дэлхийд, тэр дундаа АНУ-д маш ихээр нэмэгдэж байна. 2017-2022 оны хооронд цахилгаан дугуйтай холбоотой осол жил бүр хоёр дахин өссөн бол цахилгаан скүүтерийн осол жил бүр 45%-иар нэмэгдсэн байна.

АНУ-д эдгээр ослууд ихэвчлэн хотын төвлөрөл ихтэй бүсүүдэд тохиолдож байгаа бөгөөд судалгаанаас үзэхэд мянган аялал тутамд 115 осол тохиолддог нь бусад тээврийн хэрэгслүүдтэй харьцуулахад өндөр үзүүлэлт байна.

БНХАУ-ын Шанхай, Бээжин зэрэг хотуудад замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглосон бол ОХУ-ын Москва, Санкт-Петербург зэрэг томоохон хотуудын явган зорчигчийн хөдөлгөөн ихтэй зарим гудамжнуудаар хөдөлгөөнийг хориглосон.

АНУ, Швейцар, Итали, Англи зэрэг улсуудад 20-24 км-ээс хэтрэхгүй хурдтай (техникийн дээд хурд 24) цахилгаан скүүтерийг Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу явган хүний зам болон унадаг дугуйн замаар зорчихыг зөвшөөрсөн бол Казахстан, Дани зэрэг улс орнуудад зөвхөн 18 нас хүрсэн иргэн унаж замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрсөн зохицуулалт гаргасан.

Канад улсад мотоциклын мэргэжлийн 3 тамирчин 2014 онд 30 сая ам.долларын санхүүжилттэй инженер техникийн ажилтан 14 хүний бүрэлдэхүүнтэй "Сур-рон" компанийг анх үүсгэн байгуулж, 2018 оны 3-р сард "Light Bee X" хэмээх хөнгөн жин бүхий анхны загвар (зөгийний хэлбэр төрх, нисэх байдлаас санаа авсан)-ыг гаргаснаар дэлхий даяар алдаршиж, 70,000 гаруй ширхэг борлогдоод байна.

Тус компани нь Light Bee X (даац 70 кг, хурд 75 км/ц, 6000Вт хүчин

чадалтай) мотоцикл сонирхогчдын түвшинд, Ultra Bee (хурд 90 км/ц, даац 93 кг, 12500 Вт) болон Storm Bee (хурд 120км/ц, даац 70 кг, 22500 Вт) өндөр хүчин чадал бүхий мэргэжлийн тамирчдад зориулсан 3 төрлийн загварыг зах зээлд нийлүүлж байна.

2021 оны 10 дугаар сард Швейцарийн Женев хотноо зохион байгуулсан хуралдаанаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан тогтоолоор зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтлийг 50-аас доошгүй хувиар бууруулах үндсэн зорилт бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны **10 жилийн /2021-2030 он/ төлөвлөгөөг баталсан.**¹

Хурдыг **1 км/ц** нэмэхэд гэмтэл учрах эрсдэл **3 хувиар**, харин **4–5 хувиар** нэмэгдэхэд хүний амь нас хохирох эрсдэл үүсдэг бол зарим Улсад хурдыг бууруулах чиглэлээр хурдны хязгаарлалтыг тогтоож, түүнийг мөрдүүлсэн нь судалгаагаар хурдыг **1 км/цаг** бууруулахад зам тээврийн ослын үзүүлэлт нь **2-3 хувь буурсан** байна.

Зам тээврийн осолд 80 км/цагийн хурдтай явж байгаад орох нь 30 км/цагийн хурдтай явж байгаад орсонтой харьцуулахад үхэлд хүргэх магадлал 20 дахин их байдаг.

Манай улсын хууль, эрх зүйн зохицуулалтын талаар: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөх замын хөдөлгөөний нэгдсэн журмыг Замын хөдөлгөөний дүрмээр тогтооно” гэж заасан.²

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1.1-д “Энэ

дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний нэгдсэн журам тогтооход оршино. Замын хөдөлгөөнтэй холбоотой бусад хэм хэмжээний актууд нь энэ дүрмийн заалт шаардлагууд дээр үндэслэгдсэн, түүнтэй зөрчилдөхгүй байвал зохино” гэж тус тус заасан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.1-д “**тээврийн хэрэгсэл гэж**” хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг, 3.1.2-д “**механикжсан тээврийн хэрэгсэл**” гэж мопедоос бусад хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг, тус тус хэлэхээр тодорхойлж, Замын хөдөлгөөний дүрмээр мопед, мотоцикл, унадаг дугуй зэргийг мөн тодорхойлж өгсөн.

Мөн дүрмийн 1.2.24 “**мопед**” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр буюу гурван дугуйт тээврийн хэрэгслийг, 1.2.25. “**мотоцикл**” гэж хөдөлгүүрийн ажлын багтаамж буюу чадал, эсхүл техникийн дээд хурд нь мопедынхоос илүү, хоёр дугуйт механикжсан тээврийн хэрэгслийг. Энд өөрийн жин нь 400 кг (ачааны зориулалттай бол 550 кг)-аас хэтрэхгүй гурван дугуйт болон мотоциклын төрлийн жолооны залууртай дөрвөн дугуйт механикжсан тээврийн хэрэгсэл мөн хамаарна, 1.2.37. “**унадаг дугуй**” гэж унаж яваа хүний булчингийн хүчээр явдаг (0.25 кВт-аас илүүгүй чадал бүхий цахилгаан хөдөлгүүрээр тоноглогдсон байж болно), хоёроос цөөнгүй дугуйтай

¹ <https://mongolia.un.org/mn/about/about-the-un>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11224>

(хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцрээс бусад) тээврийн хэрэгслийг;) гэж тус тус тодорхойлжээ.¹

Дүгнэлт: Дээрх тоон мэдээллээс харахад хүүхэд, залуучууд өдөр тутмын хэрэглээнд цахилгаан скүүтер, цахилгаан мопед, Surron ашиглан замын хөдөлгөөнд оролцож байгаа нь 2024 оны эхний 9 сарын байдлаар 142 хүн гэмтэж, 2 хүн нас барсан харамсалтай тоон мэдээ гарч байгаа тул цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Мөн 18-аас доош насны хүүхэд, залуучуудыг түрээсийн цахилгаан скүүтер, цахилгаан мопедийг унуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгож хэрэв унаж хөдөлгөөнд оролцсон тохиолдолд эцэг, эх асран хамгаалагчид хариуцлага тооцох механизмыг бий болгох нь зүйтэй.

Хуваариа цахилгаан скүүтер, цахилгаан мопед худалдан авч ашиглаж байгаа иргэдэд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгож хөдөлгөөнд оролцох чадамжийг дээшлүүлэх, явган зорчигчийн замаар явахгүй байх талаар эрх зүйн зохицуулалт шаардлагатай.

Замын хөдөлгөөний дүрэмд заасан насны хязгаарлалт, хориглосон зам, зорчих хэсэг, эгнээгээр зорчсон зэрэг зөрчлүүдийг гаргасан тохиолдолд зорчих боломжгүй болох цахим хяналтын системүүдийг хийх, зорчилтын мэдээлэл солилцож ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна.

Санал: Стандарт, хэмжил зүйн газраас 2021 онд баталсан

“Автотээврийн хэрэгсэл, Мотоцикл ерөнхий шаардлага” MNS 6933:2021 стандартыг шинэчлэн боловсруулж, мотоциклийн төрөлд хамаарах загвар, хөдөлгүүр, ажлын чадал, хурдны үзүүлэлт, техникийн шаардлагуудыг тодорхой тусгах, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан “Мотоцикл” тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлтэд хамаарах тээврийн хэрэгсэл (суррон, кросс г.м)-ийг бүртгэлжүүлж, улсын дугаар олгох. Ингэснээр 18-аас доош насны хүүхэд залуучууд унах боломжгүй бөгөөд зөвхөн “А” ангиллын жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн жолоодох эрхтэй болно.

“Автотээврийн хэрэгсэл, Мопед ерөнхий шаардлага” MNS: :2024 стандартыг шинээр боловсруулж, мопедын төрөлд хамаарах загвар, хөдөлгүүр, ажлын чадал, хурдны үзүүлэлт, техникийн шаардлагуудыг тодорхой тусган баталж мөрдүүлэх, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан “Мопед” тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлтэд хамаарах тээврийн хэрэгсэл (цахилгаан скүүтер г.м)-ийг бүртгэлжүүлж, аль төрлийн тээврийн хэрэгсэл болохыг мэдээлэх гэрчилгээ (цахим гэрчилгээ)-тэй болгох, эзэмшигчийн мэдээллийг холбогдох байгууллагуудтай солилцох боломжтой болгох ба 16 наснаас доош насны хүн жолоодох боломжгүй болно.

Эх сурвалжийн жагсаалт:

1. ЦЕГ, “Монгол Улсын Цагдаагийн түүхэн баримт бичгийн эмхэтгэл”, 2021 он, УБ хот;
2. ЗЦГ, “Замын цагдаагийн албаны түүхэн товчоо”, 2016 он, УБ хот
3. ТЦА, “Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол,

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13641>

зөрчлийн статистик үзүүлэлтийн
эмхэтгэл”, 2024 он, УБ хот;

Ашигласан цахим хуудас:

1. <https://legalinfo.mn>

2. <https://un.org>

3. <https://1212.mn>

4. <https://roadsafety.gov.mn>